



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот


Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилтуудыг хангах, санхүүжилтийн эх үүсвэрийн уялдааг сайжруулах, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг санхүүжүүлэх механизмыг боловсронгуй болгох, хөгжлийн санхүүжилтийн хяналт, үнэлгээ, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор "Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөө"-г нэгдүгээр, "Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт"-ийг хоёрдугаар, "Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн удирдлага, зохицуулалт"-ыг гуравдугаар, олон улсын хөгжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, дэмжлэг, зээл тусламжийг Засгийн газрын бодлого, чиглэлтэй уялдуулах үүрэг бүхий "Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн хорооны бүрэлдэхүүн"-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Санхүүгийн бодлогын газар /Л.Сонор/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т даалгасугай.


Б.ЖАВХЛАН

9763000535

ҮНДЭСНИЙ САНХҮҮЖИЛТИЙН НЭГДСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨ /2024-2028/

Сангийн сайдын 2024 оны 19 дугаар сарын 10 өдрийн
177 дугаар тушаалын нэгдүгээр хавдарт

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	
				Үндсэн	Хамтрах
I	ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ				
1.1	Үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх				
1.1.1	Дэд бүтэц, Нийгэм, Байгаль орчны салбарын төсөвт зарлагын шинжилгээг хийж гүйцэтгэх	2024-2026	Зарлагын шинэчилсэн аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн салбарын тоо		
1.1.2	Үр дүнд суурилсан төсөвлөлтийн туршилтыг зарим яамдад үргэлжлүүлэх, туршилтыг цаашид бусад яамнуудад шинээр эхлүүлэх	2024-2026	Үр дүнд суурилсан төсөвлөлтийг туршиж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн салбарын тоо	Салбар яамд	СЯ, Олон улсын байгууллагууд
1.1.3	Үр дүнд суурилсан төсөвлөлтөд бүрэн шилжих	2026-2028	Үр дүнд суурилсан төсөвлөлт руу шилжсэн төсвийн хувь		
1.2	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх				
1.2.1	Салбаруудын төсөвт жендерийн шинжилгээ хийх	2026-2028	Жил бүр жендерт суурилсан төсөв боловсруулах замаар хуваарилсан зардлын хэмжээ	Салбар яамд	СЯ, ЖҮХ, Олон улсын байгууллагууд
1.2.2	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал, гарын авлагыг боловсруулах	2026	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал гарын авлага боловсруулагдсан байдал	СЯ	ЖҮХ, Олон улсын байгууллагууд
1.2.3	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг зарим бусад яамдад турших	2024-2027	Төсөвлөлт хийхдээ жендерийн асуудлыг харгалзан үзсэн салбарын төсвийн нийт салбарын тоонд эзлэх хувь	Салбар яамд	СЯ, ЖҮХ, Олон улсын байгууллагууд
1.2.4	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сайн туршлагыг салбар, орон нутаг,	2027-2028	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сайн туршлагын тоо	СЯ	Салбарын яамд, ЖҮХ,

	байгууллагын сурталчлах	түвшинд	гаргаж			
1.2.5	Жендерт уялдсан төсвийн ангиллыг ашиглан жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн зарцуулалтыг хянах	2024-2028	Жил бүр жендерт суурилсан төсөв боловсруулах замаар хуваарилсан зардлын хэмжээ	СЯ	ЖҮХ	
1.3	ТХЗ, ногоон хөгжилтэй уялдсан төсвийн ангиллыг нэвтрүүлэх					
1.3.1	Төсвийн зарлагын ангиллын системийг боловсруулах	2024	Төсвийн зардлыг ТХЗ-тай уялдуулан ангилах системийг боловсруулсан эсэх		СЯ	Салбар яамд, Олон улсын байгууллагууд
1.3.2	Ногоон хөгжилтэй уялдсан төсвийн хөрөнгө оруулалтын ангиллыг боловсруулах	2024				
1.3.3	Ногоон хөгжилтэй уялдсан төсвийн зарлагын ангиллыг боловсруулах	2024-2025				
1.3.4	ТХЗ-уудтай уялдсан төсөвлөлтийн аргачлалыг боловсруулах	2026				
1.3.5	ТХЗ, ногоон хөгжилтэй уялдсан төсөвлөлтийг турших	2024-2027	Ангиллын дагуу ТХЗ, ногоон хөгжилтэй нийцүүлсэн хуваарилсан нийт зардлын хэмжээ	Салбар яамд	СЯ, НҮБХХ	
1.3.6	Төсвийн ТХЗ, ногоон хөгжилтэй уялдуулан ангилдаг болох	2026-2028	Улсын нийт төсөвт эзлэх ТХЗ, ногоон хөгжлийг дэмжихэд хуваарилагдсан төсвийн хувь	СЯ	НҮБХХ	
1.4	Байгаль орчны татварын шинэчлэлийг хийх					
1.4.1	Ногоон (хог хаягдал, бохирдол, эрчим хүч, тээвэр, нөөц ашигласны гэх мэт) татварын тогтолцоог бэхжүүлэх, өргөжүүлэх	2024-2025	Шинээр нэвтэрсэн ногоон/байгаль орчны татварын тогтолцооны тоо	СЯ	ТЕГ, БОУАӨЯ	
1.4.2	Нүүрсний бохирдлын татварыг нэмэгдүүлэх, нүүрс төрөлчийн татварыг нэвтрүүлэх, судлах	2024		СЯ	ТЕГ, БОУАӨЯ	
1.4.3	Монгол Улсын татварын тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэх цогц шийдэл болох Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай (ТХЗ) уялдсан Татварын орчны үнэлгээ гаргах	2024-2025	ТХЗ-той уялдсан татварын орчны үнэлгээ гаргасан байна. Уг үнэлгээнд суурилан сайжруулах ажлын зөвлөмж болон төлөвлөгөө гаргана.	СЯ	ТЕГ, Салбарын яамд	

1.5	Баялгийн сангийн үйл ажиллагааг хөгжүүлэх				
1.5.1	Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэх	2024	Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн эсэх	СЯ	Салбарын яамд
1.5.2	Үндэсний баялгийн сангийн тухай хуульд ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг тусгах	2024		СЯ	ЗГХЭГ, АУЭБЯ
1.6	Тогтвортой хөгжлийн бонд гаргах бэлтгэл ажлыг хангах				
1.6.1	Тогтвортой хөгжлийн бондын баримт бичгийг батлуулах	2025	Тогтвортой хөгжлийн бондын баримт бичгийг боловсруулж, батлуулсан байна.	СЯ	Олон улсын байгууллагууд
1.6.2	Засгийн газар, эсхүл аймаг нийслэлийн тогтвортой хөгжлийн бондын эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг судлах	2026	Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор гаргах бондын санхүүжүүлж болох төсөл хөтөлбөрийг тодорхойлох	СЯ	Олон улсын байгууллагууд
1.6.3	Тогтвортой хөгжлийн бондын зарцуулалтын үр нөлөөг хэмжих, тайлагнах чадавхыг бэхжүүлэх	2026	Тогтвортой хөгжлийн бондын зарцуулалтын үр нөлөөг хэмжих аргачлалыг боловсруулах	СЯ	Олон улсын байгууллагууд
1.7	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийг шинэчлэх				
1.7.1	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ийн шинээр батлагдсан тогтвортой хөгжил, уур амьсгалын тайлагналын S1, S2 стандартыг Монгол Улсад нэвтрүүлэх суурь судалгаа, ажлын төлөвлөгөө, туршилтын нэвтрүүлэлтийг Төрийн өмчит компаниудтай хамтран зохион байгуулах	2024-2026	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын шинээр батлагдсан тогтвортой хөгжил, уур амьсгалын тайлагналын S1, S2 стандартыг Монгол Улсад нэвтрүүлэхэд төрийн өмчит компанийн оролцоог хангах, туршилтын нэвтрүүлэлт, тайлагнал хийж гүйцэтгэх, Энэхүү ажлын хүрээнд төрийн өмчит арилжааны Банк-1, төрийн өмчит даатгал, санхүүгийн байгууллага – 1, тус бүр хамруулах	СЯ, ТӨБЗГ	Олон улсын байгууллагууд
1.7.2	Төрийн өмчит компаниудад БОНЗ, ТХЗ-уудын тайлагналын стандартыг нэвтрүүлэх	2024-2025	БОНЗ-ын тайлагналын стандартыг нэвтрүүлсэн ТӨК-ийн тоо	ТӨБЗГ	ТӨК-ууд, Олон улсын байгууллагууд

1.7.3	ТӨК-уудын засаглалыг сайжруулах (Мэргэжлийн холбоодын төлөөлөл оруулах гэх мэт)	2024-2026	ТӨК-уудын нийт өр төлбөрийн хэмжээ нийт улсын төсөвт эзлэх хувь	ТӨБЗГ	ТӨК-ууд
1.8	Төрийн тогтвортой худалдан авалтын зарчмуудыг нэвтрүүлэх				
1.8.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль эрх зүйн орчныг сайжруулах	2024	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах орчныг сайжруулах чиглэлээр, бодлого дүрэм журам шинээр гарсан эсвэл өөрчлөгдөн шинэчлэгдсэн эсэх	СЯ	ТХААГ
1.8.2	Төрийн тогтвортой худалдан авалтын зарчим, арга зүйг нэвтрүүлэх	2024	Төрийн тогтвортой худалдан авалтын зарчим, арга зүйг нэвтрүүлэн ашиглаж байгаа төрийн өмчит байгууллагуудын тоо, Засгийн газрын нийт худалдан авалт дахь ногоон худалдан авалтын эзлэх хувь	СЯ	Салбарын яамд, ТХААГ, ТӨБЗГ, ТӨК-ууд
1.8.3	Монгол Улсын худалдан авалтын эрсдэлийн үнэлгээг хийх.	2024-2026		СЯ	Салбарын яамд, ТӨК-ууд, АХБ
1.9	Олон улсын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх				
1.9.1	ТХЗ-ууд болон үндэсний хөгжлийн зорилтуудыг хангахад хөгжлийн хамтрагч байгууллагуудаас авах техникийн болон санхүүгийн тусламжийг нэмэгдүүлэх	2024-2025		СЯ	Салбар яамд, Олон улсын байгууллагууд, МБ, СЗХ
1.9.2	Шинэ төслүүдэд хамтран ажиллах боломжийг эрэлхийлж, олон улсын хамтрагч байгууллагуудыг өргөжүүлэх	2024-2028	Техникийн болон санхүүгийн тусламжаар олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо (тухайн жилд үргэлжилж байгаа болон дууссан)	СЯ	Салбар яамд, Олон улсын байгууллагууд, МБ, СЗХ
1.9.3	Хөгжлийн түнш байгууллагуудаас авсан эзэлээр санхүүжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн зарцуулалтын ил тод байдлыг хангах	2024-2026		СЯ	Салбар яамд, Олон улсын байгууллагууд, МБ, СЗХ
1.9.4	Олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулж, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах	2024-2028		СЯ	Салбар яамд, Олон улсын байгууллагууд, МБ, СЗХ
II	Хувийн хэвшлийн санхүүжилт				

2.1	Санхүүгийн зах зээлийн хөгжлийг ТХЗ-уудтай нийцүүлэх					
2.1.1	Ногоон хөгжлийн санхүүжилтийн стандартыг санхүүгийн салбарын хэмжээнд нэвтрүүлэх	2025-2028	Санхүүгийн салбарт ногоон санхүүжилтийн нэвтрүүлсэн байгууллагын тоо	МБ, СЗХ	МУХАУТ, Олон улсын байгууллагууд, Арилжааны банкууд	
2.1.2	Холимог санхүүжилтийн бүтээгдэхүүнийг турших (Эрсдэл хуваалцах механизм)	2024-2025	Холимог санхүүжилттэй төсөл хөтөлбөр, бүтээгдэхүүний тоо	МБ, СЗХ		
2.2	ТХЗ-д чиглэсэн үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах стандарт (ТХЗ-ын санхүүжилтийн таксономий)-ыг нэвтрүүлэх					
2.2.1	ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн төслийг бэлтгэж батлуулах, зааварчилгааг боловсруулах	2024	ТХЗ-ын таксономийг түүнийг ашиглах зааврын хамт боловсруулж батлуулсан эсэх	СЯ	МБ, НҮБХХ, Холбоо	СЗХ, НҮБХХ, Тос
2.2.2	ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг арилжааны банкуудад нэвтрүүлэх	2025	Санхүүгийн салбарын нийт ТХЗ-д нийцсэн зээл дэх ангилал тус бүрийн зээлийн эзлэх хувь	МБ	НҮБХХ, Холбоо, Арилжааны банкууд	Тос
2.2.3	ТХЗ-д чиглэсэн санхүүжилтийн статистик гаргах, мэдээллийн бааз бүрдүүлэх	2025-2027	ТХЗ-д чиглэсэн санхүүжилт, үйл ажиллагааны талаар шинээр үүссэн статистик мэдээллийн тоо	МБ, СЗХ	УСХ, Санхүүгийн байгууллагууд	
2.2.4	ТХЗ-д чиглэсэн шинэ санхүүжилтийн бүтээгдэхүүн гаргах нөхцөлийг бүрдүүлэх (ТХЗ-ын зээл, ТХЗ-той уялдсан зээл, ТХЗ ХОС гэх мэт)	2024-2028	ТХЗ-д чиглэсэн шинэ санхүүгийн бүтээгдэхүүний тоо	МБ, СЗХ	НҮБХХ, Холбоо, Арилжааны банкууд	Тос
2.2.5	ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг санхүүгийн салбарт бүхэлд нь нэвтрүүлэх	2024-2025		МБ, СЗХ	НҮБХХ, Холбоо, Санхүүгийн байгууллагууд	Тос
2.3	Тогтвортой хөрөнгө оруулалтын санг бий болгох					
2.3.1	Тогтвортой хөрөнгө оруулалтын санг дэмжих эрх зүйн зохицуулалт болон хөшүүргийг бий болгох	2024-2025	ТХЗ-д чиглэсэн хөрөнгө оруулалтын сангийн тоо	СЯ	МХБ, Олон улсын байгууллагууд	

2.3.2	ТХЗ-ын нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангийн стандарт (SDG Impact Standards for Private Equity Funds)-ыг нэвтрүүлэх	2024-2028		СЗХ	МБ, НҮБХХ
2.4	Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг ТХЗ-уудтай нийцүүлэх				
2.4.1	НҮБ-ын Тогтвортой хөрөнгийн биржийн санаачилгын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх (Тогтвортой байдлын тайлан, тогтвортой байдлын индекс г.м)	2024-2025	БОНЗ-ын тайлагналын стандартыг мөрдөж байгаа хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудын тоо	МХБ	ТӨБЗГ, НҮБХХ
2.4.2	БОНЗ-ын тайлагналын стандарт, боловсруулж, ХК-уудад мөрдүүлдэг болох	2024		СЗХ	МХБ, Тос холбоо, ОУСК, НҮБХХ
2.4.3	Хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй ААН-уудад жендер, хүний эрхийн зарчим, стандартуудыг нэвтрүүлэх	2024-2025	Жендер, Бизнес ба хүний эрхийн зарчим, стандартуудыг нэвтрүүлсэн хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудын тоо	СЗХ	МХБ, ЖҮХ
2.4.4	ЕСБХБ-аас гаргасан Тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын хөшүүрүүдийг нэвтрүүлэх	2024		СЗХ	МХБ, ЕСБХБ
2.4.5	Биржийн бус зах зээлийн зохицуулалтын уян хатан тогтолцоог бүрдүүлэх	2024-2025		СЗХ	ҮЦАЭХ
2.4.6	Шинээр гарч буй үнэт цаасыг ТХЗ-ын таксономийн дагуу ангилдаг болох	2024	Дотоодын зах зээлд гаргасан бондын нийт үнийн дунд ТХЗ-д нийцсэн дотоодын бондын эзлэх хувь	СЗХ	МХБ, НҮБХХ, Тос холбоо
2.4.7	ТХЗ-ын нөлөөллийн байгууллагын болон бондын стандартыг нэвтрүүлэх (SDG Impact Standards for Enterprises and Bonds)	2024-2025		СЗХ	МХБ, НҮБХХ
2.4.8	ТХЗ-ын бонд, ногоон бонд туршилтаар гаргах	2024-2025	Дотоодын зах зээлд Засгийн газар болон хувийн компаниудын гаргасан ТХЗ-ын бондын хэмжээ	СЗХ	МХБ
2.4.9	Гарааны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хялбарчилж, МХБ-д мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хүрээнд арилжаалах самбар бий болгох	2024		МХБ	СЗХ
2.4.10	FTSE Russell компанийн Фронтлиер зах зээлийн албан ёсны зэрэглэлтэй болох	2024	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь	МХБ	СЗХ
2.5	Дотоодын институциональ хөрөнгө оруулагчдыг бий болгох				

2.5.1	Хөрөнгө оруулалтын сан, Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Хөрөнгө оруулалтын сан /ХОМК-ХОС-ийн харилцааг олон улсын жишигт нийцүүлэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2024	ХОС-ийн зохицуулалтуудын талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	СЯ	СЗХ, МХБ, УЦАЭХ, ХОМК-ууд, ХОС-ууд
2.5.2	СЗХ-ны ХОС-ийн холбогдох журмуудад хуулийн нэмэлт өөрчлөлттэй нийцүүлэн өөрчлөлт оруулах	2024-2025		СЗХ	МХБ, УЦАЭХ, ХОМК-ууд, ХОС-ууд
2.5.3	Хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог нэвтрүүлэх	2024-2026	Институциональ хөрөнгө оруулагчдын дотоодын зах зээлд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, Их наяд төгрөгөөр	СЗХ	ГЕХНХЯ, МХБ
2.5.4	Биржээр арилжааагаддаг сангийн журам боловсруулах	2024-2025		МХБ	СЗХ
2.5.6	Үл хөдлөх хөрөнгийн сангууд (REIT)-ийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх	2024-2026		СЗХ	МХБ, УЦАЭХ
2.5.7	Хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэлийн тайлагналын стандарт (GIPS)-ыг нэвтрүүлэх	2024-2026	Гүйцэтгэлийн тайлагналын стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж буй ХОС-ийн тоо	СЗХ	МХБ, ХОМК-ууд, ХОС-ууд
2.5.8	ТХЗ-ын нөлөөллийн стандартыг ХОС-уудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх (SDG impact standards for private equity funds)	2024-2028	ТХЗ-ын нөлөөллийн стандартыг үйл ажиллагаандаа ашиглаж буй ХОС-ийн тоо	СЗХ	ХОМК-ууд, ХОС-ууд, МХБ, НҮБХХ
III	ӨРИЙН БОЛОН САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ СТРАТЕГИ				
3.1	ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ				
3.1.1	Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.	2024-2028	Засгийн газрын гадаад өрийн дундаж хугацаа	СЯ	Монголбанк
3.1.2	Болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх	2024	Засгийн газрын өрийн жигнэсэн дундаж хүү	СЯ	Монголбанк
3.1.3	Засгийн газрын ТХЗ-д нийцсэн бондын хүрээ боловсруулан батлуулах	2024-2025	Баримт бичиг батлагдсан эсэх	СЯ	ЗГХЭГ

3.1.4	Өрийн тогтвортой шинээлэг санхүүжилтийн арга хэрэгсэл (Үүсмэл хэрэгсэл, ТХЗ-ын бонд, ногоон бонд гэх мэт) ашиглан дахин санхүүжүүлэх боломжийг эрэлхийлэх, судлах	2024-2025	Холбогдох судалгаа хийгдсэн эсэх	СЯ	Олон улсын байгууллагууд
3.1.5	Хөгжлийн томоохон төслүүдийн эрсдэлийг хуваалцах замаар, хувийн хэвшлийн төслүүдийг дэмжих.	2024-2025	Хөгжлийн томоохон төслүүдэд гаргасан зээл, баталгаа, батлан даалтын дүнгийн улсын нийт өрийн дүнд зэлэх хувь	СЯ	ЭЗХЯ

IV ҮНДЭСНИЙ САНХҮҮЖИЛТИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООНЫ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

4.1	Олон талууд зөвлөлдөх, хамтран ажиллах тогтолцоог бэхжүүлэх				
4.1.1	ТХЗ-ын санхүүжилтийн форумыг зохион байгуулж, бүх талууд зөвлөлдөх практикийг хэвшүүлэх	2024-2028	Олон талуудын хэлэлцүүлэг өрнүүлэх ТХЗ-ын санхүүжилтийн форумыг зохион байгуулж буй давтамж	СЯ	Салбарын яамд, Олон улсын байгууллагууд
4.2.2	ҮСНТ-ийг хэрэгжүүлж буй бусад улс орнуудтай туршлага солилцох	2024-2028	Тогтвортой санхүүжилтийн чадавхыг бэхжүүлэх сургалтад хамрагдагсдын тоо	СЯ	Салбарын яамд, Олон улсын байгууллагууд
4.1.3	ҮСНТ-ийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхэд хөгжлийн түншүүдтэй хамтран ажиллах	2024-2028		СЯ	Салбарын яамд, Олон улсын байгууллагууд

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж	СЯ	Сангийн яам
АУЭБЯ	Аж уйлдвэр, эрдэс баялгийн яам	СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
БОНЗ	Байгаль орчны ногоон зээл	ТЕГ	Татварын ерөнхий газар
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	ТӨБГЗ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ТӨК	Төрийн өмчит компани
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн яам	ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ЖУХ	Жендерийн үндэсний хороо	ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	ҮСНТ	Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги
МБ	Монгол банк	ҮЦАЭХ	Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
СЯ	Сангийн яам	ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

сайдлын 2024 оны /D/ дугаар
сарын 10 өдрийн ... дугаар
аллын хоёрдугаар хавсралт

Сангийн дайдын 2024 оны /D/ дугаар дарын /D/ өдрийн ... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Стратегийн үр дүн, гарц, үйл ажиллагаа		Шалгуур үзүүлэлтүүд	ТХЗ-ын холбогдох ШҮ-ийн дугаар	Суурь түвшин	Зорилтот түвшин				Мэдээллийн давтамж	Хариуцах байгууллага	
1. ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ											
ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын санхүүжилт нэмэгдсэн байна.	Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн ДНБ-д эзлэх хувь	Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын ДНБ-д эзлэх хувь	17.1.2	34.6%	>36.5%	>36.5%	>36.5%	жилээр	СЯ	СЯ	
		Засгийн газрын дотоод зээлийн ДНБ-д эзлэх хувь		28.9%	31.7%	32.0%	32.0%	жилээр	СЯ	СЯ	
		Хөгжлийн албан ёсны тусламжийн ДНБ-д эзлэх хувь		4.3%	4.9%	5.0%	5.0%	жилээр	СЯ	СЯ	
				1.7%	1.5%	1.5%	1.5%	жилээр	СЯ	СЯ	
		Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь		51.8%	41.0%	>60.0%	>60.0%	жилээр	СЯ	СЯ	
		Улсын нэгдсэн төсвийн нийт орлогод Хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	17.3.1	5.0%	5.0%	5.0%	5.0%	жилээр	СЯ	СЯ, ЭЗХЯ	
		Төлөвлөлт, төсөвлөлт болон дунд болон урт хугацааны үндэсний хөгжлийн зорилго, зорилтуудын уялдаа сайжирсан байна.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэлийн хувь хэмжээ	16.6.1	96.2%	95.0%	97.0%	98.0%	жилээр	СЯ	СЯ
Төрийн өмчит ААН, санхүүгийн байгууллагуудад	Төрийн өмчийн ААН, санхүүгийн байгууллагуудаас Тогтвортой байдлын тайланг	0	5	10	50	жилээр	ТӨБЭЗГ	ЭЗХЯ, ТӨБЭЗГ			

	тогтвортой санхүүжилтийн зарчим, БОНЗ-ын стандардуудыг нэвтрүүлж, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлнэ.	(БОНЗ) хэвлэдэг ААН, байгууллагын тоо								
		Засгийн газрын нийт худалдан авалт дахь ногоон худалдан авалтын эзлэх хувь	12.7.1	0					жилээр	СЯ, ТХААГ
Гарц	Үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх	Үр дүнд суурилсан төсөвлөлт руу шилжсэн салбарын тоо		4	6	8	бүх салбар	жилээр	СЯ	СЯ
	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх	Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг туршиж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн салбарын тоо		2	3	4	бүх салбар	жилээр	СЯ	СЯ
	ТХЗ-уудтай уялдсан төсвийн ангиллыг нэвтрүүлэх (SDG budget tagging)	ТХЗ-уудтай уялдсан төсвийн ангиллыг нэвтрүүлсэн салбарын тоо		-	8	12	бүх салбар	жилээр	СЯ	СЯ
	Төрийн тогтвортой худалдан авалтын зарчмуудыг нэвтрүүлэх	Төрийн тогтвортой худалдан авалтын зарчим, арга зүйг нэвтрүүлэн ашиглаж байгаа төрийн өмчит байгууллагуудын тоо	12.7.1	0				жилээр	СЯ, ТХААГ	СЯ, ТХААГ
	ТХЗ-уудтай уялдсан төсөвлөлтийн аргачлалыг боловсруулах	ТХЗ-уудтай уялдсан төсөвлөлтийн аргачлалыг боловсруулж, батласан эсэх		Үгүй	Үгүй	Тийм	Тийм	жилээр	СЯ	СЯ
Үйл ажиллагаа	Төсвийн тухай хуульд ТХЗ-тай уялдсан төсөвлөлтийг тусгах	Төсвийн тухай хуульд ТХЗ-тай уялдсан төсөвлөлтийн талаар холбогдох заалтууд тусгагдсан эсэх		Үгүй	Үгүй	Тийм	Тийм	жилээр	СЯ	СЯ
	Төсвийн орлого нэмэгдүүлэх стратегиудыг нэвтрүүлэх	Татварын орлогын ДНБ-д эзлэх хувь		31.3%	34.2%	35.0%	35.0%	жилээр	СЯ	СЯ
	Байгаль орчны татварын шинэчлэлийг хийх	Шинээр нэвтэрсэн ногоон/байгаль орчны татварын төрөл, хэлбэрийн тоо		3	0	0	0	жилээр	СЯ	СЯ

Баялгийн сангийн үйл ажиллагааг хөгжүүлэх	Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн эсэх		Үгүй	Үгүй	Тийм	Тийм	жилээр	СЯ	СЯ
Төрийн өмчит компаниудад БОНЗ, ТХЗ-уудын тайлагналын стандартыг нэвтрүүлэх	БОНЗ-ын тайлагналын стандартыг нэвтрүүлсэн ТӨК-ийн тоо		Үгүй	Үгүй	Тийм	Тийм	жилээр	ТӨБЭГ	

II. ХУВИЙН СЕКТОРЫН САНХҮҮЖИЛТ

Үр дүн	ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн гадаад дотоодын хувийн хэвшлийн санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэн байна.	ГШХО-ын ДНБ-д эзлэх хувь		17.3.1	20.0%	20.0%	25.0%	30.0%	жилээр	МБ	ЭЗХЯ
		Хувийн секторын дотоод зээлийн ДНБ-д эзлэх хувь	Хувийн секторын гадаад зээлийн ДНБ-д эзлэх хувь		18.8%	19.0%	20.0%	25.0%	жилээр	МБ	СЗХ
		Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь			136.1%	137.0%	140.0%	140.0%	жилээр	МБ	-
		Санхүүгийн салбарын олгосон ногоон зээлийн нийт салбарын зээлд эзлэх хувь			14.4%	20.0%	25.0%	30.0%	жилээр	СЗХ	-
		Санхүүгийн салбарын олгосон ногоон зээлийн нийт салбарын зээлд эзлэх хувь			0.7%	1.0%	3.0%	5.0%	жилээр	МБ, СЗХ	-
		ТХЗ-д чиглэсэн шинэ санхүүгийн бүтээгдэхүүний тоо			2	6	12	21	жилээр	МБ, СЗХ,	СЯ
Гарц	Тогтвортой хөрөнгө оруулалтын санг бий болгох	ТХЗ-д чиглэсэн хөрөнгө оруулалтын сангийн тоо			0	1	3	5	жилээр	СЗХ	-
	Хувийн хэвшлийн оролцоотой Байгаль хамгаалах итгэлцлийн сан (Conservation trust fund) байгуулах	Хувийн хэвшлийн оролцоотой Байгаль хамгаалах итгэлцлийн сан (Conservation trust fund) байгуулсан эсэх			Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	жилээр	СЗХ	БОУАӨЯ
	Холимог санхүүжилтийн бүтээгдэхүүнийг турших (Эрсдэл хуваацах механизм)	Холимог санхүүжилттэй бүтээгдэхүүний тоо			0	0	1	3	жилээр	СЗХ	МБ
	ТХЗ-ын бонд, ногоон бонд туршилтаар гаргах	Дотоодын зах зээлд гаргасан бондын нийт үнийн дүнд ТХЗ-д			0	1.0%	2.0%	3,0%	жилээр	СЗХ	МХБ

	ТХЗ-д чиглэсэн үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах стандарт (ТХЗ-ын санхүүжилтийн таксономи)-ыг нэвтрүүлэх	ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн дагуу зохих мэдээ тайлан гаргадаг байгууллагын тоо	0	30	40	50	жилээр	МБ, СЗХ	-
	БОНЗ-ын тайлагналын стандарт, боловсруулж, мөрдүүлдэг болох	БОНЗ-ын тайлагналын стандартыг мөрдөж байгаа хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-уудын тоо	9	15	30	40	жилээр	МХБ	СЗХ
	Хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог нэвтрүүлэх	Хувийн тэтгэврийн сангийн тоо	0	0	2	5	жилээр	СЗХ	-
	ТХЗ-ын нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангийн стандарт (SDG Impact Standards for Private Equity Funds)-ыг нэвтрүүлэх	ТХЗ-ын нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангийн стандартыг баталсан эсэх	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	жилээр	СЗХ	МХБ
	Шинээр гарч буй үнэт цаасыг ТХЗ-ын таксономийн дагуу ангилдаг болох зохицуулалтыг бий болгох	Шинээр гарч буй үнэт цаасыг ТХЗ-ын таксономийн дагуу ангилдаг болох зохицуулалтыг бий болсон эсэх	Үгүй	Тийм	Тийм	Тийм	жилээр	СЗХ	МХБ
Үйл ажиллагаа	ЕСБХБ-аас гаргасан Тогтвортой хөрөнгө	Тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих нэвтрүүлсэн бодлогын хөшүүргийн тоо					жилээр	СЗХ	МХБ

	оруулалтыг дэмжих бодлогын хөшүүрлүүдийг нэвтрүүлэх								
	Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулж болох хөрөнгүүдийн жагсаалт, эрхлэх хугацаа, Хөрөнгө оруулалтын менежментийн компани, Хөрөнгө оруулалтын сан /ХОМК-ХОС/-ийн харилцааг олон улсын жишигт нийцүүлэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	ХОС-ийн зохицуулалтуудын талаарх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх							
	Үл хөдлөх хөрөнгийн сангууд (REIT)-ийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үл хөдлөх хөрөнгийн сангууд (REIT)-ийг бий болгох эрх зүйн орчин бүрдсэн эсэх	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	СЭ
	Хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэлийн тайлагналын стандарт (GIPS)-ыг нэвтрүүлэх	Гүйцэтгэлийн тайлагналын стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж буй ХОС-ийн тоо	0	2	5	10	жилээр	СЭХ	МХБ
III. ӨРИЙН БОЛОН САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ СТРАТЕГИ									
Үр дүн	Өрийн тогтвортой байдал, макро эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангаж, эрсдэлийн	Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь	196.0%	195.0%	195.0%	195.0%	жилээр	СЯ	СЯ

Удирдлагыг сайжруулна.									
Хувийн хэвшлийн оролцогч талуудын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	100,000 насанд хүрэгчдэд ногдох арилжааны банкны салбарын тоо	8.10.1 (a)	55.6	56	56	56	жилээр	МБ	МБ
	100,000 насанд хүрэгчдэд ногдох арилжааны банкны АТМ-ын тоо	8.10.1 (b)	122	125	130	135	жилээр	МБ	МБ
	Санхүүгийн салбарын багтаамж /их наяд төгрөгөөр/	8.10.2	6.9	7.5	9.2	20.7	жилээр	МБ, СЗХ	МБ, СЗХ

Сангийн сайдын 2024 оны 10 дугаар
сарын 10 өдрийн 17 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

1. Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн удирдлага, зохицуулалтын механизм

Монгол Улсын тогтвортой хөгжлийн санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны удирдлага, зохицуулалт нь хөгжлийн санхүүжилтийн бодлого, эх үүсвэр, хэрэгсэл, оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах, нэгдмэл байдлыг хангах, үр нөлөө, ашгийг дээшлүүлэх чиглэсэн болно. Монгол Улсын тогтвортой хөгжлийн санхүүжилтийн удирдлага, зохицуулалтын механизм нь бодлогын болон техникийн түвшингээс бүрдэнэ.

2. Бодлогын түвшинд:

Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн хороо: Энэ тушаалаар байгуулж буй Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн хороо нь тогтвортой хөгжлийн үндэсний санхүүжилтийн төлөвлөгөөнд туссан бодлогын шинэчлэл, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүжилтийн уялдаа холбоог хангах, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

3. Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн уялдаа холбоог хангах хороо

- **Зорилго:** Олон улсын хөгжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүжилтийг Монгол Улсын ТХЗ-ийг хангахад Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, үр ашигтай ажиллах.
- **Удирдлага:** Тогтвортой хөгжлийн Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжүүлэхэд удирдлага, Засгийн газар болон олон улсын түнш байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, тэргүүлэх чиглэлийг тогтооно.
- **Бодлогын уялдаа:** Монгол улсын тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг санхүүгийн эх үүсвэрүүдтэй уялдуулах.
- **Санхүүгийн эх үүсвэр тодорхойлох:** Тогтвортой хөгжлийн Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох.
- **Чадавх бэхжүүлэх:** Тогтвортой хөгжлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх.

Удирдлагын бүтэц:

Дарга:

- Сангийн сайд

Дэд дарга:

- Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга
- Эдийн засаг хөгжлийн яамны Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын газрын дарга

Олон улсын байгууллага:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр болон бусад харьяа агентлагийн төлөөлөл;
- Европын холбооны төлөөлөл;
- Олон Улсын Валютын Сангийн төлөөлөл;
- Дэлхийн банкны төлөөлөл;
- Олон Улсын Санхүүгийн корпорацийн төлөөлөл
- Азийн Хөгжлийн Банкны төлөөлөл;
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны төлөөлөл;
- Даян дэлхийн ногоон хөгжлийн институт

Үйл ажиллагаа:

Хурал: Удирдах хороо нь жилд нэг удаа Тогтвортой хөгжлийн Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хэлэлцэж, дараа жилийн тэргүүлэх чиглэл, ажлын төлөвлөгөөг батална.

Шаардлагатай тохиолдолд Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн удирдах хорооны даргын санаачилгаар жилд нэгээс дээш хуралдаж болно.

Тайлан: Сангийн яамны тогтвортой хөгжлийн санхүүжилтийг хариуцсан нэгж Тогтвортой хөгжлийн Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн тайланг боловсруулж, хэрэгжилтийн үр дүнг олон нийтэд танилцуулна.

Ажлын алба: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар нь тус хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын алба нь болно.

Шийдвэр гаргах:

Зөвшилцлийн үндсэн дээр шийдвэр гаргана. Санал нэгдээгүй тохиолдолд хурал даргалагч шийдвэрлэх эрхтэй байна.

Хугацаа:

Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн хороо нь Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөө хэрэгжих хугацаанд буюу 2024-2028 он хүртэл ажиллана.



Сангийн сайдын 2024 оны 10 дугаар
сарын 10 өдрийн 177 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга	Сангийн сайд
Хорооны дэд ахлагчид	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга
	Эдийн засаг хөгжлийн яамны Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын газрын дарга
Хорооны гишүүд	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр болон бусад харьяа агентлагийн төлөөлөл;
	Европын холбооны төлөөлөл;
	Олон Улсын Валютын Сангийн төлөөлөл;
	Дэлхийн банкны төлөөлөл;
	Олон Улсын Санхүүгийн корпорацын төлөөлөл
	Азийн Хөгжлийн Банкны төлөөлөл;
	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны төлөөлөл;
	Даян дэлхийн ногоон хөгжлийн институт
Хорооны нарийн бичиг	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга